

ОЛОН УЛСЫН ЗАХ ЗЭЭЛ

АНУ: АНУ-ын хөрөнгийн зах зээлийн индексүүд буурсан үзүүлэлттэй байна. Урт хугацаат Засгийн газрын үнэт цаасны өгөөж буурснаар S&P 500 индексийн сагсанд багтаж буй үл хөдлөх хөрөнгө, ус, дулаан, цахилгаан хангамжийн компаниудын хувьцааны ханш өсжээ. Харин газрын тосны үнэ унаснаар эрчим хүч, аж үйлдвэрийн салбарт үйл ажиллагаа явуулдаг компаниудын хувьцааны ханш буурсан үзүүлэлттэй байна. Томоохон эм үйлдвэрлэгч компани болох "Phizer" компанийн хувьцааны ханш огцом буурчээ.

АНУ-ын гадаад худалдааны алдагдал 2018 онд 621 тэрбум ам.доллар болж, сүүлийн 10 жилийн дээд түвшинд хүрлээ. АНУ гаалийн татварын хэмжээг бууруулснаар импортын бараа, бүтээгдэхүүний эрэлт нэмэгдээд байгаа ажээ. АНУ-ын Худалдааны яамны мэдээлснээр, гадаад худалдааны алдагдал жилийн дүнгээр 12.5 хувь буюу 68.8 тэрбум ам.доллараар нэмэгджээ. Түүнчлэн худалдааны маргааны гол шалтгаан болсон БНХАУ-тай хийсэн гадаад худалдааны алдагдал нь өнгөрсөн онд 419.2 тэрбум ам.доллар буюу түүхэн дээд түвшиндээ хүрч өссөн байна.

БНХАУ-ын Төв банкны тэргүүн И Ган Бүх Хятадын Ардын Төлөөлөгчдийн Их Хурлын чуулганы үеэр хийсэн мэдэгдэлдээ "АНУ-тай олон чухал асуудлаар зөвшилцөлд хүрсэн" талаар мэдээллээ.

Европ: Европын төв банк 2019 он дуустал бодлогын хүүний түвшиндээ өөрчлөлт оруулахгүй талаар мэдээлж, Европын бүсийн хөрөнгийн зах зээлийн индексүүд буурчээ.

Европын төв банк Европын бүсийн бус нутгийн эдийн засгийн таамгаа 1.7%-аас 1.1% болгож бууруулжээ. Ингэснээр еврогийн ханш ам.долларын эсрэг суларч, Европын бүсийн бондын өгөөж буурчээ. Европын төв банкны мэдэгдлийн дараа банкуудын хувьцааны ханш 4 орчим хувиар буурсан байна.

Их Британийн Ерөнхий сайд Тереза Мэй BREXIT-ийн хэлэлцээрийн төслийг дэмжихийг Парламентын гишүүдээс шаардлаа. Их Британийн Парламент гуравдугаар сарын 12-нд BREXIT-ийн хэлэлцээрийн төслөөр санал хураана. Хэрэв тус улсын Парламент Тереза Мэйн төслийг дэмжихгүй бол Парламентын гишүүд BREXIT-ийн товыг хойшлуулах эсвэл Европын Холбооноос хэлэлцээр хийхгүйгээр гарах эсэхэд санал хураах юм байна.

Япон: Японы хөрөнгийн зах зээлийн Nikkei 225 индекс 2.7 хувиар буурч 21,025.56 нэгж боллоо.

1-р сард Японы суурь инфляцийн түвшин 0.1 хувиар өсөж 0.8 хувьд хүрсэн байна.

Японы эдийн засгийн яамны мэдээлснээр 1-р сард Японы аж үйлдвэрлэлийн гарц маш хурдацтай буурчээ. Цахилгаан гэр ахуйн бараа бүтээгдэхүүн, авто машины үйлдвэрлэлийн гарц буурсан бол жижиглэнийн худалдааны салбар бага зэргийн өсөлт үзүүлжээ.

Эх сурвалж: Reuters, Troweprice

Олон улсын индексүүд

| Индекс | Улс | Хаалт | Өөрчлөлт |
|-------------|------------|-----------|----------|
| MSE TOP 20 | Монгол | 21,040.41 | -0.19% ▼ |
| Dow Jones | АНУ | 25,450.24 | -2.21% ▼ |
| S&P 500 | АНУ | 2,743.07 | -2.16% ▼ |
| Nasdaq | АНУ | 7,408.14 | -2.46% ▼ |
| S&P/TSX | Канад | 15,996.21 | -0.45% ▼ |
| FTSE 100 | Их Британи | 7,104.31 | -0.03% ▼ |
| S&P/ASX 200 | Австрали | 6,203.80 | 0.18% ▲ |
| Nikkei 225 | Япон | 21,025.56 | -2.67% ▼ |
| Hang Seng | Хонг Конг | 28,228.42 | -2.03% ▼ |

Бондын өгөөж

| Бонд | Валют | Купон | Үнэ |
|------------------------|-------|---------|--------|
| Mongol 2024 (Хуралдай) | USD | 8.750% | 111.34 |
| Mongol 2023 (Гэрэгэ) | USD | 5.625% | 99.60 |
| Mongol 2022 (Чингис) | USD | 5.125% | 99.18 |
| Mongol 2021 (Мазаалай) | USD | 10.875% | 111.35 |
| DBM' 23 (Самурай) | JPY | 1.520% | 104.65 |
| DBM' 2023 | USD | 7.250% | 102.75 |
| TDBM' 2020 | USD | 9.375% | 104.21 |

Зах зээлийн хүү

| Хүү | Хаалт | Өөрчлөлт |
|--------------|-------|----------|
| Libor 1M | 2.490 | 0.01 ▲ |
| Libor 3M | 2.596 | 0.00 ▲ |
| Libor 6M | 2.679 | 0.00 ▲ |
| Libor 1YR | 2.863 | -0.02 ▼ |
| US 2YR Bond | 2.469 | -0.09 ▼ |
| US 3YR Bond | 2.441 | -0.10 ▼ |
| US 5YR Bond | 2.434 | -0.12 ▼ |
| US 10YR Bond | 2.636 | -0.12 ▼ |

Валютын ханш /төг/

| Валют | 2019.03.07 | Өөрчлөлт |
|-------|------------|----------|
| USD | 2,634.61 | -0.03% ▼ |
| CNY | 392.74 | -0.14% ▼ |
| EUR | 2,979.35 | -0.61% ▼ |
| RUB | 39.95 | -0.27% ▼ |
| KRW | 2.33 | -0.43% ▼ |
| JPY | 23.57 | 0.00% ▼ |
| CAD | 1,960.64 | -2.30% ▼ |

Түүхий эдийн үнэ

| Түүхий эд | Хэмжих нэгж | Хаалт | Өөрчлөлт |
|------------------|-------------|----------|----------|
| Алт /spot/ | USD/t oz. | 1,298.30 | 0.34% ▲ |
| Мөнгө /spot/ | USD/t oz. | 15.34 | 0.72% ▲ |
| Зэс | USD/lb. | 289.35 | -1.58% ▼ |
| Нүүрс | USD/MT | 93.50 | -3.11% ▼ |
| WTI газрын тос | USD/bbl. | 56.07 | 0.09% ▲ |
| Brent газрын тос | USD/bbl. | 65.74 | 0.61% ▲ |
| Байгалийн хий | USD/MMBtu | 2.87 | 0.70% ▲ |

Макро эдийн засгийн үзүүлэлтүүд

| Үзүүлэлт | Хугацаа | Хэмжээ |
|----------------------------------|---------|--------|
| Инфляцийн түвшин | 2019. I | 7.30% |
| Бодлогын хүү | 2019. I | 11.00% |
| Банк хоорондын зах зээлийн хүү | 2019. I | 11.10% |
| Хадгаламжийн дундаж хүү /төгрөг/ | 2019. I | 12.10% |
| Хадгаламжийн дундаж хүү /валют/ | 2019. I | 4.90% |
| Зээлийн дундаж хүү /төгрөг/ | 2019. I | 16.80% |
| Зээлийн дундаж хүү /валют/ | 2019. I | 10.60% |

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо, Монголбанк, Bloomberg

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖИЙН АРИЛЖАА

Энэ 7 хоногт Монголын хөрөнгийн биржийн хоёрдогч зах зээлийн энгийн арилжаагаар 42 компанийн 460.5 сая төгрөгийн 1,639,708 ширхэг хувьцаа арилжигдав.


“Оллоо” /OLL/ компанийн хувьцаа 13.79%-аар буюу хамгийн ихээр өсч 85.0 төгрөгт хүрч хаагдсан бол “Техник импорт” /TEX/ компанийн хувьцаа 22.74%-аар буурч 13,830.0 төгрөгт хүрч хаагдлаа.

Мөн тайлант долоо хоногт ЗГҮЦ-ны анхдагч бзах зээл дээр арилжаа хийгдээгүй.

ЗГҮЦ-ны хоёрдогч зах зээл дээр нийт 8,990 ширхэг үнэт цаас 939.8 сая төгрөгөөр арилжаалагджээ.


3-р сарын 7-ний өдрийн байдлаар зах зээлийн үнэлгээ 2,467.9 тэрбум төгрөгт хүрсэн бол MSE TOP-20 Индекс 21,040.41 нэгж болж өмнөх 7 хоногийн үзүүлэлтээс 0.19%-аар буурсан байна.

MSE Индекс



Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж

Арилжааны үнийн дүн /7 хоногоор, 2019 он/



*2018 оны 12-р сарын 31-ний өдрийн арилжааг хасан тооцсон

Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж

Зах зээлийн хураангуй

| Хураангуй | Үнийн дүн /сая төг/ |
|-----------------------|---------------------|
| Арилжигдсан үнийн дүн | 1,400.2 |
| Зах зээлийн үнэлгээ | 2,467,853.9 |

Зах зээлийн индекс

| Индекс | Хаалт | Өөрчлөлт |
|---------------|-----------|----------|
| MSE Top 20 | 21,040.41 | -0.19% ▼ |
| MSE I индекс | 9,724.90 | -0.06% ▼ |
| MSE II индекс | 8,405.93 | -0.42% ▼ |

Идэвхтэй арилжигдсан хувьцаа

| Компани | Ширхэг | Үнийн дүн /төг/ |
|--------------|---------|-----------------|
| Ард даатгал | 219,727 | 152,972,812 |
| АПУ | 169,637 | 107,183,463 |
| ЛэндМН ББСБ | 757,994 | 51,735,092 |
| Говь | 155,701 | 49,736,698 |
| Таван толгой | 2,349 | 16,708,015 |

Өсөлттэй хувьцаа

| Компани | Хаалт /төг/ | Өөрчлөлт |
|---------------------------|-------------|----------|
| Оллоо | 85.00 | 13.79% ▲ |
| Адуунчулуун | 1,700.00 | 9.68% ▲ |
| Жинст-Увс | 1,800.00 | 8.43% ▲ |
| Эрдэнэ ресурс | 556.11 | 7.01% ▲ |
| девелопмент корп. | | |
| Монголын цахилгаан холбоо | 450.00 | 5.16% ▲ |

Бууралттай хувьцаа

| Компани | Хаалт /төг/ | Өөрчлөлт |
|----------------------|-------------|-----------|
| Техник импорт | 13,830.00 | -22.74% ▼ |
| Баянгол зочид буудал | 29,460.00 | -13.35% ▼ |
| Монгол савхи | 501.00 | -12.87% ▼ |
| Баянтээг | 24,000.00 | -12.41% ▼ |
| Дархан зочид буудал | 80.00 | -10.60% ▼ |

Арилжаанд идэвхтэй оролцсон үнэт цаасны компаниуд

| Компани | Арилжааны үнийн дүн /төг/ |
|------------------------------|---------------------------|
| Мирэ Эссет Секьюритис Монгол | 2,604,662,842 |
| Новел инвестмент | 1,085,026,315 |
| Ард секьюритиз | 279,794,613 |
| Голомт капитал | 197,967,966 |
| Би Ди Сек | 119,477,797 |

Зах зээлийн үнэлгээ хамгийн өндөр 5 компани

| Компани | Хаалт /төг/ | ЗЗҮ /сая.төг/ |
|--------------|-------------|---------------|
| АПУ | 633.62 | 674,287 |
| Таван толгой | 7,130.00 | 375,503 |
| МИК | 12,800.00 | 265,079 |
| Говь | 316.26 | 246,718 |
| Сүү | 214.32 | 73,726 |

НОГДОЛ АШИГ ЗАРЛАСАН ХУВЬЦААТ КОМПАНИУД

| № | Симбол | Компанийн нэр | 2018 оны цэвэр ашиг /сая төг/ | Нийт хуваарилах ногдол ашиг /сая төг/ | Ногдол ашиг төлөлтийн харьцаа | Нэгж хувьцааны ногдол ашиг /төг/ | Шийдвэр огноо | Бүртгэлийн өдөр | Хуваарилах өдөр |
|----|--------|---|-------------------------------|---------------------------------------|-------------------------------|----------------------------------|---------------|-----------------|-----------------------|
| 1 | HRM | Гермес центр ХК | 783.4 | 298.5 | 38.1% | 3.8 | 2019.01.25 | 2019.02.18 | 2019.03.15 |
| 2 | LEND | ЛендМН ББСБ | 2,560.3 | 800.0 | 31.2% | 1.0 | 2019.01.30 | 2019.02.22 | 2019.05.01-ний дотор |
| 3 | MBW | Монгол Базальт ХК | 217.2 | 56.4 | 26.0% | 1.0 | 2019.02.01 | 2019.03.25 | 2019.10.01-с |
| 4 | BTG | Баянтээг ХК | 1,771.4 | 1,000.0 | 56.5% | 3,958.7 | 2019.02.11 | 2019.03.04 | 2019.06.01-с |
| 5 | SUL | Жуулчин дюти фрий ХК | 1,384.5 | 653.6 | 47.2% | 10,000.0 | 2019.02.12 | N/A | 2019.05.31-с |
| 6 | GOV | Говь ХК | 17,764.2 | 5,304.8 | 29.9% | 6.8 | 2019.02.13 | N/A | 2019.04.25-с |
| 7 | ADU | Хөвсгөл алтан дуулга ХК | 399.2 | 1,888.1 | 473.0% | 120.0 | 2019.02.13 | N/A | 2019.05.01-с |
| 8 | TCK | Талх чихэр ХК | 1,975.9 | 204.7 | 10.4% | 200.0 | 2019.02.14 | N/A | 2019.07.01-с |
| 9 | MMX | Мах импекс ХК | 778.6 | 456.1 | 58.6% | 120.0 | 2019.02.14 | N/A | 2019.10.01-с |
| 10 | BUK | УБ-БУК ХК | 566.4 | 131.5 | 23.2% | 1.0 | 2019.02.14 | N/A | 2019.05.01-с |
| 11 | TAN | Тахь-ко ХК | 799.1 | 128.5 | 16.1% | 108.0 | 2019.02.15 | N/A | 2019.05.01-ний дотор |
| 12 | MNP | Монгол шуудан ХК | 1,560.3 | 468.1 | 30.0% | 4.7 | 2019.02.18 | N/A | 2019.05.01-с |
| 13 | HRD | Хүрд ХК | N/A | 74.4 | N/A | 550.0 | 2019.02.18 | 2019.03.04 | 2019.06.01-ний дотор |
| 14 | MNDL | Мандал даатгал ХК | 3,868.3 | 624.3 | 16.1% | 100.0 | 2019.02.18 | N/A | 2019.05.01-2019.05.31 |
| 15 | GTL | Гутал ХК | 2,225.8 | 1,257.7 | 56.5% | 777.0 | 2019.02.18 | 2019.03.13 | 2019.05.06-с |
| 16 | TEX | Техник импорт ХК | 2,702.0 | 723.4 | 26.8% | 500.0 | 2019.02.18 | 2019.03.11 | 2019.04.11-с |
| 17 | APU | АПУ ХК | 57,851.7 | 48,952.4 | 84.6% | 46.0 | 2019.02.19 | N/A | 2019.12.31-ний дотор |
| 18 | AIC | Ард даатгал ХК | 1,263.4 | 631.8 | 50.0% | 25.3 | 2019.02.19 | 2019.03.15 | 2019.06.29-ний дотор |
| 19 | GHC | Ган хийц ХК | 20.3 | 12.1 | 59.7% | 50.0 | 2019.02.19 | 2019.03.22 | 2019.10.01 |
| 20 | TAL | Талын гал ХК | 255.9 | 34.7 | 13.6% | 50.0 | 2019.02.25 | 2019.03.26 | N/A |
| 21 | BRC | Барилга корпораци ХК | 1,311.0 | 40.1 | 3.1% | 985.0 | 2019.02.26 | 2019.03.18 | N/A |
| 22 | UBH | Улаанбаатар хивс ХК | 235.6 | 48.6 | 20.6% | 120.0 | 2019.02.26 | 2019.03.18 | 2019.05.31-ний дотор |
| 23 | DSS | Дархан Сэлэнгийн цахилгаан түгээх сүлжээ ХК | 11.5 | 11.4 | 99.2% | 1.1 | 2019.03.01 | 2019.03.21 | 2019.07.02 |

ЗГҮЦ БОЛОН КОМПАНИЙН БОНДЫН АРИЛЖАА

ЗГҮЦ-ны хоёрдогч зах зээл

| № | Үнэт цаасны нэр | Арилжигдсан ширхэг | Үнийн дүн /төг/ | Доод /төг/ | Дээд /төг/ | 7 хоног | Хүү |
|---|-------------------------------|--------------------|-----------------|------------|------------|---------|---------|
| 1 | ZGEB-BD-04/07/19-A0266-14.82 | 226 | 22,707,350 | 100,150 | 100,800 | 104 | 14.820% |
| 2 | ZGEB-BD-22/05/20-A0248-15.87 | 5,562 | 580,580,100 | 103,630 | 105,330 | 156 | 15.870% |
| 3 | ZGEB-BD-25/04/20-A0236-16.993 | 2,502 | 265,762,440 | 106,220 | 106,220 | 156 | 16.993% |
| 4 | ZGEB-BD-26/09/19-A0326-13.955 | 700 | 70,707,000 | 101,010 | 101,010 | 104 | 13.955% |

ЭЭЛЖИТ ХУРАЛ ЗАРЛАСАН ХУВЬЦААТ КОМПАНИУД

| № | Симбол | Компанийн нэр | Бүртгэлийн өдөр | Хуралдах өдөр | Хуралдах цаг |
|----|--------|---|-----------------|---------------|--------------|
| 1 | SVR | Эрдэнэт суврага ХК | 2019.02.08 | 2019.03.11 | 11:00 |
| 2 | BLG | Завхан баялаг ХК | 2019.02.27 | 2019.03.18 | 10:00 |
| 3 | LEND | ЛэндМН ББСБ ХК | 2019.02.22 | 2019.03.23 | 12:00 |
| 4 | DLH | Эм Эн Ди ХК | 2019.03.11 | 2019.03.28 | 15:00 |
| 5 | EAZ | Эрдэнэт авто зам ХК | 2019.03.14 | 2019.03.29 | 10:00 |
| 6 | BTG | Баянтээг ХК | 2019.03.04 | 2019.04.01 | 10:00 |
| 7 | GTL | Гутал ХК | 2019.03.10 | 2019.04.01 | 11:00 |
| 8 | АНН | Хоринхоёрдугаар бааз ХК | 2019.03.11 | 2019.04.01 | 13:00 |
| 9 | MNB | Мон Наб ХК | 2019.03.14 | 2019.04.04 | 14:00 |
| 10 | MIB | Монинжбар ХК | 2019.02.05 | 2019.04.05 | 14:30 |
| 11 | HRD | Хүрд ХК | 2019.03.04 | 2019.04.05 | 16:00 |
| 12 | VIK | Баян-Алдар ХК | 2019.03.04 | 2019.04.08 | 10:00 |
| 13 | HUZ | Хөвсгөл усан зам ХК | 2019.02.28 | 2019.04.08 | 09:00 |
| 14 | MIE | Материалимпекс ХК | 2019.03.11 | 2019.04.09 | 10:30 |
| 15 | HRL | Хэрлэн хивс ХК | 2019.03.21 | 2019.04.09 | 10:00 |
| 16 | AZH | Алтайн зам ХК | 2019.03.19 | 2019.04.10 | 16:00 |
| 17 | BHL | Бөөний худалдаа ХК | 2019.03.14 | 2019.04.10 | 16:00 |
| 18 | DBL | Даваанбулаг ХК | 2019.03.23 | 2019.04.10 | 14:00 |
| 19 | ALI | Стандарт ноос ХК | 2019.03.18 | 2019.04.10 | 15:00 |
| 20 | CND | АСБИ ХК | 2019.03.22 | 2019.04.11 | 10:00 |
| 21 | DSS | Дархан Сэлэнгийн цахилгаан түгээх сүлжээ ХК | 2019.03.21 | 2019.04.11 | 11:00 |
| 22 | TEX | Техникимпорт ХК | 2019.03.11 | 2019.04.11 | 15:00 |
| 23 | UBH | Улаанбаатар хивс ХК | 2019.03.18 | 2019.04.11 | 11:00 |
| 24 | DES | Дорнод худалдаа ХК | 2019.03.22 | 2019.04.12 | 14:00 |
| 25 | NEH | Дархан нэхий ХК | 2019.03.23 | 2019.04.21 | 12:00 |
| 26 | TLP | Тулпар ХК | 2019.03.11 | 2019.04.15 | 15:00 |
| 27 | BRC | Барилга корпораци ХК | 2019.03.18 | 2019.04.18 | 10:00 |
| 28 | DAZ | Дорнод авто зам ХК | 2019.03.25 | 2019.04.18 | 15:00 |
| 29 | BDS | Би Ди Сек ХК | 2019.03.22 | 2019.04.23 | 10:00 |
| 30 | SHV | Шивээ овоо ХК | 2019.03.14 | 2019.04.25 | 14:00 |
| 31 | GHC | Гах хийц ХК | 2019.03.22 | 2019.04.26 | 11:40 |
| 32 | NRS | Шинэст ХК | 2019.03.20 | 2019.04.26 | 10:00 |
| 33 | AIC | Ард даатгал ХК | 2019.03.15 | 2019.04.27 | 09:00 |
| 34 | MBW | Монгол базальт ХК | 2019.03.25 | 2019.04.29 | 15:00 |
| 35 | BSKY | Блюскай секьюритиз ХК | 2019.03.20 | 2019.04.30 | 18:00 |
| 36 | TAL | Талын гал ХК | 2019.03.26 | 2019.04.30 | 14:00 |


ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН МЭДЭЭ

Нэр бүхий 21 хувьцаат компанийг бүртгэлээс хаслаа

“Монголын хөрөнгийн бирж” ТӨХК нь бүртгэлтэй хувьцаат компаниудын үүргийн хэрэгжилтийг хангуулах замаар хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах, зах зээлийн хөрвөх чадварыг нэмэгдүүлэх чиглэлээр шат дараалсан арга хэмжээнүүдийг авч ажиллаж байгаа билээ. Энэхүү арга хэмжээний хүрээнд, МХБ-ийн үнэт цаасны бүртгэлийн шалгуур, шаардлага хангахгүй байгаа хувьцаат компаниудад хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ биелүүлэх хугацаатай үүрэг даалгавар өгч, заасан хугацаанд холбогдох зөрчлийг арилгаагүй компаниудыг бүртгэлээс хасах хүртэл арга хэмжээг авч байгаа болно.

Үүний дагуу, үнэт цаасны арилжааг зогсоосноос хойш 1 жилээс дээш хугацаанд арилжаа сэргээгүй буюу арилжааг зогсоох нөхцөл шалтгаан нь арилагагүй дараах нэр бүхий 21 компанийг Компанийн тухай хуулийн 83 дугаар зүйлийн 83.1, Санхүүгийн зохицуулах хорооны “Үнэт цаасны бүртгэлийн журам”-ын 3 дугаар зүйлийн 3.2.1, 3.2.10 дахь заалтууд, “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК-ийн Дүрмийн 8 дугаар зүйлийн 8.10.11, “Үнэт цаасны бүртгэлийн журам”-ын 23 дугаар зүйлийн 23.11.4 дэх заалтыг тус тус үндэслэн “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК-ийн Гүйцэтгэх захирлын 2019 оны 3 дугаар сарын 04-ний өдрийн А/20 тоот тушаалаар Монголын хөрөнгийн биржийн үнэт цаасны бүртгэлээс хаслаа. Үүнд: “Еврофё Азия” ХК, “Мон-Асар” ХК, “Харгиа” ХК, “Сав шим” ХК, “Алмаас” ХК, “Баянтоорой” ХК, “Мөнх жим” ХК, “Өв-Усжуулагч” ХК, “Төв Ус” ХК, “Хангал” ХК, “Чандмань уул” ХК, “Харшийн гэгээ” ХК, “Баялаг шарын гол” ХК, “Ар тархи” ХК, “Бүтээл” ХК, “Дорнод тээвэр” ХК, “Жинст” ХК, “Их нуур” ХК, “Их үүсгэл” ХК, “Сэлэнгэ импекс” ХК, “Чандмань Дундговь” ХК.

Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж



“Ард кредит ББСБ” ХК-ийн үнэт цаасны хоёрдогч зах зээлийн арилжаа 2019.03.12-нд эхэлнэ

Санхүүгийн зохицуулах хорооноос 2019 оны 3 дугаар сарын 11-ний өдөр ирүүлсэн 1/820 тоот албан бичгийн дагуу “Ард Кредит ББСБ” ХК-ийн үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжааг амжилттай болсонд тооцож, хоёрдогч зах зээлийн арилжааг 2019 оны 3 дугаар сарын 12-ны өдрөөс эхлүүлэхээр боллоо.

Тус компанийн хувьцааны анхдагч зах зээлийн арилжааны захиалга олон нийтэд санал болгосон дүнгээс 3 дахин давж ирсэн бөгөөд нийт ирүүлсэн захиалгын дийлэнх нь 85 төгрөгөөр ирсэн хэдий ч үнэт цаас гаргагч “Ард Кредит ББСБ” ХК болон андеррайтерийн компани болох “Ард Капитал ҮЦК” ХХК-ийн зүгээс МХБ-ийн журам, хөрөнгө оруулагчдад өгөх өгөөжийг харгалзан үзэж нэгж хувьцааны нийлүүлэх үнийг нийт ирүүлсэн захиалгын тоо хэмжээгээр жигнэсэн дундаж ханш буюу 81 төгрөгөөр тогтоож, ирүүлсэн захиалгын 43.73 хувиар хувь тэнцүүлэн тооцож хуваарилалт хийсэнтэй холбогдуулан хөрөнгө оруулагчид тус үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжааны төлбөрийн үлдэгдэл мөнгөн хөрөнгийг өнөөдрөөс буцаан авах эрх үүслээ.

Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж

ҮЦТХТ: II сард шинээр нээсэн дансны тоо өмнөх сараас 60 хувиар бага байв

2019 оны хоёрдугаар сард нийт 39,490 шинэ үнэт цаасны данс, 2200 гаруй холболтын данс нээсэн талаар Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв мэдээллээ. Энэ нь нэгдүгээр сарынхаас 60 орчим хувиар буурсан үзүүлэлт болж байна.

2018 онд Монголын Хөрөнгийн бирж, Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв хөрөнгийн зах зээлийг хөгжүүлж, идэвхжүүлэхээр хөдөө орон нутгийн иргэдэд танилцуулга хийж, данс нээсэн юм. Энэ хүрээнд үнэт цаасны данс нээлгэсэн иргэдийн тоо огцом нэмэгдэж, үнэт цаасны данстай иргэдийн тоо нэг сая давжээ.

Үүнээс гадна “Эрдэнэс Тавантолгой”-ийн IPO-той холбоотойгоор данс нээлгэх иргэдийн идэвх өссөн гэж Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв мэдээлж байв. Мөн урд өмнө нь Монголын Хөрөнгийн биржид бүртгүүлж байгаагүй салбарын компаниуд хөрөнгийн захад гарч эхэлсэн нь энэ захын тоглолчдыг нэмсэн гэж Монголын Хөрөнгийн бирж үзэж байгаа аж.

Шинээр нээсэн дансны 30 гаруй хувийг “Өндөрхаан инвест” болон “Таван богд” үнэт цаасны компаниуд нээжээ. Өөрөөр хэлбэл дээрх хоёр үнэт цаасны компаниуд хоёрдугаар сард нийт 13 орчим мянган данс нээсэн байна.

Эх сурвалж: BloombergTv.mn

ЗГҮЦ-ны арилжааны идэвх оны эхний 2 сард өмнөх оны мөн үеэс 13 дахин буураад байна

Хоёрдугаар сард Монголын Хөрөнгийн бирж 13,350 сая төгрөгийн үнэт цаас арилжсан байна. Үүнээс 10 тэрбум төгрөг нь хувьцааны анхдагч зах зээлийн арилжаа байжээ. Нэгдүгээр сард “Түмэн шувуут” компани 10 тэрбум төгрөгийг дотоодын ухаас татсан байна.

Санхүүгийн зохицуулах хороо анхдагч зах зээлийн арилжааг хоёрдугаар сарын эхэнд амжилттай болсонд тооцож баталсан учраас 10 тэрбум төгрөгийн арилжаа ийнхүү хоёрдугаар сарын арилжааг өсгөж өгсөн юм.

Тус компанийн татан төвлөрүүлсэн хөрөнгийн хэмжээ 2018 оны IPO-уудын татсан дүнгийн 30 гаруй хувьтай нь дангаараа тэнцэж байна. Харин хоёрдугаар сард хувьцааны хоёрдогч зах зээлийн арилжаа болон Засгийн газрын үнэт цаасны арилжаа гурван тэрбум 350 сая төгрөгөөр хэмжигдэж байна. Энэ нь нэгдүгээр сартай ойролцоо дүн болж байгаа ба өмнөх оны мөн үеэс 23 хувиар өссөн үзүүлэлт болжээ.

Хоёрдугаар сард АПУ, “ЛэндМН”, “Говь” компанийн хувьцааны арилжаа идэвхтэй байсан юм. АПУ компанийн хувьцаа сар бүр идэвхээрээ тэргүүлэгчдийн нэг байдаг бол “Говь” компани хувьцаагаа хувааснаас хойш арилжааны идэвх нь нэмэгдээд байна.

Харин Засгийн газрын үнэт цаасны арилжаа хоёрдугаар сард нийт үнэт цаасны арилжааны 34 хувийг бүрдүүлжээ. Засгийн газрын үнэт цаасны арилжаа 1.2 тэрбум төгрөгөөр хэмжигдэж байгаа нь өмнөх сараас гурав дахин өндөр дүн болж байна.

2017 оны 11 дүгээр сард Засгийн газрын үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжаа зогссоноос хойш Засгийн газрын үнэт цаасны арилжааны идэвх эрс буураад байгаа юм. Өөрөөр хэлбэл, 2017 онд Монголын Хөрөнгийн биржийн нийт арилжааны 90 орчим хувийг дангаараа бүрдүүлж байсан Засгийн газрын үнэт цаасны арилжаа 2018 онд нийт арилжааны ердөө 13.7 хувийг бүрдүүлжээ. Тухайлбал, 2018 оны эхний хоёр сард 21 тэрбум төгрөгийн Засгийн газрын үнэт цаасны хоёрдогч зах зээлийн арилжаа хийж байсан бол энэ он гарсаар хоёр тэрбум төгрөг хүрэхгүй Засгийн газрын үнэт цаас арилжаад байна.

Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж

ТҮҮХИЙ ЭДИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН МЭДЭЭ

ГЕГ: 2019 оны эхний 2 сарын экспортын 75.5 хувийг эрдэс бүтээгдэхүүний экспорт бүрдүүлэв

2019 оны эхний 2 сард нийт экспортын 75.5 хувь буюу 826.2 сая ам.долларын экспортыг эрдэс бүтээгдэхүүн бүрдүүлэв. Түүнчлэн 17.9 хувь буюу 195.9 сая ам.долларын экспорт нь үнэт ба хагас үнэт чулуу, үнэт металл, гоёлын зүйлсийн экспорт байсан талаар Гаалийн ерөнхий газар мэдээлэв.

Экспортлогдсон эрдэс бүтээгдэхүүнийг зах зээлээр нь задлаад харвал, газрын тос, төмрийн хүдэр, зэсийн баяжмал болон цайрын баяжмалыг 100 хувь, чулуун нүүрсний 97.9 хувийг БНХАУ-д нийлүүлсэн байна. Харин жоншны 67 хувийг БНХАУ-д, 31.9 хувийг ОХУ-д нийлүүлсэн талаар ГЕГ мэдээллээ. II сард Монгол, БНХАУ-ын Сар шинийн баяр тохиосонтой холбоотойгоор олон хоног дараалсан амралтын өдрүүд үргэлжилсэн. Энэ нь боомтууд дээр экспорт буурахад тодорхой хэмжээнд нөлөөлсөн байна.

Монгол Улс эрдэс бүтээгдэхүүн, тэр дундаа нүүрсний экспортыг 42 сая тоннд хүргэх зорилт тавьсан. Үүнд гааль боомтын шинэчлэл чухал гэж Сангийн яам үзэж байгаа. 2019 оны төсөвт гаалийн байшин, барилга, тоног төхөөрөмж зэрэг иж бүрэн шинэчлэлд 80 орчим тэрбум төгрөг төсөвлөсөн. Энэ хүрээнд хилийн боомтууд дээр эрдэс бүтээгдэхүүн, газрын тос, автобензин, дизель түлшний төрөлжсөн лабораториудыг үе шаттай байгуулахаар төлөвлөөд байгаа.

Мөн гаалийн лабораторийн үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлэх зэрэг ажил хийх юм. Гэхдээ “Эдийн засгийн өсөлтийг дэмжих хил гаалийн шинэчлэл оройтож байгаа” тухай “Засгийн газрын мэдээ” сонин мэдээлжээ. Нүүрс, эрдэс бүтээгдэхүүний гол боомтууд дээр ажил харахан эхлээгүй байгаа талаар “Шивээхүрэн”, “Булган”, “Бичигт”-ийн боомт мэдээллээ.

Эх сурвалж: BloombergTv.mn

Citigroup: Төмрийн хүдрийн ханш 2019 оны дунд гэхэд 100 ам.доллар хүрч өсөх төлөвтэй

Нийлүүлэлтэд үүсэж байгаа саатлын улмаас энэ оны дунд үе гэхэд төмрийн хүдрийн ханш 100 ам.доллар хүрч өсөж магадгүй гэж “Citigroup” үзэж байна. Төмрийн хүдрийн ханш хамгийн сүүлд 2014 оны тавдугаар сард энэ цэгт хүрч байжээ.

“Citigroup”-ийн шинжээчдийн үзэж байгаагаар “Vale” компанийн Бразил дахь төмрийн хүдрийн уурхайн ослын улмаас ханшид үүсэх нөлөөлөл бүрэн илэрч дуусаагүй байна. Өөрөөр хэлбэл ослоос шалтгаалсан нийлүүлэлтийн хомсдол цаашид ханшид нөлөөлөх хүчин зүйл болсоор байна гэж харж байгаа ажээ. Нэгдүгээр сарын 25-нд болсон уурхайн ослоос хойш дэлхийн хэмжээнд төмрийн хүдрийн нийлүүлэлт дөрвөн хувиар хумигдсан гэж тооцоолоод байна.

Эрэлт талаас нь харвал энэ онд БНХАУ-д гангийн эрэлт нэг хувиар өсөх төлөвтэй байгаагаас шалтгаалаад үйлдвэрлэл нэмэгдэж магадгүй байна. Энэ нь төмрийн хүдрийн ханшийг өсгөх нэмэлт хүчин зүйл болно гэж үзжээ.

“Vale”-ийн ослын дараа төмрийн хүдрийн ханш өсөж, хоёрдугаар сарын найманд тонн нь 91.5 ам.доллар хүрсэн нь 2017 оны гуравдугаар сараас хойших хамгийн өндөр дүн болсон байна.

Эх сурвалж: BloombergTv.mn

Shenhua Ningxia Coal Industry Group: БНХАУ-ын нүүрсний ханш тогтвортой байх төлөвтэй

“БНХАУ-ын нүүрсний ханш харьцангуй тогтвортой байх төлөвтэй байна” гэж Бүх Хятадын Ардын Төлөөлөгчдийн Их Хурлын чуулган дээр “Shenhua Ningxia Coal Industry Group”-ийн тэргүүн Шао Жиньжэе онцоллоо.

Тэрбээр “Нүүрсний олборлолтыг өнгөрсөн оны түвшинд нь хадгалах болно” гэдгийг мөн онцолсон байна. Түүнчлэн БНХАУ-д энэ онд нүүрсний хэрэглээ өсөж магадгүй гэсэн таамгийг “China Energy Investment”-ийн Ерөнхий менежер Лин Вэн дэвшүүллээ. Нүүрсний ханш тогтворжиж, өсөлт хязгаарлагдах төлөвтэй байгаа нь нийлүүлэлтийн хэмжээнээс шалтгаалж байна гэж “Bloomberg Intelligence”-ийн шинжээчид тайлбарлаж байгаа юм. БНХАУ-ын Засгийн газрын барьж байгаа цэвэр эрчим хүчинд чиглэсэн урт хугацааны бодлого ч мөн нүүрсний ханшийг өсгөхгүй байх нэг хүчин зүйл болж байна гэж үзэж байна.

Үүнээс гадна БНХАУ-ын нүүрсний салбарын төлөвийн шинэ таамгийг “Citigroup” гаргаад байна. БНХАУ-ын Засгийн газрын тайлангаас харахад энэ онд нүүрс болон металл олборлогчдод нэлээд эерэг байх дүр зурагтай байна гэж тус банк онцоллоо. Ялангуяа “China Shenhua Energy”, “Chalco” тэргүүтэй уул уурхайн салбарын томоохон дөрвөн компанид илүү ээлтэй байх төлөвтэй гэсэн байна. Салбарын хэмжээнд хэд хэдэн нэгдэн, нийлэх хэлцэл хийгдсэнээр ган болон өнгөт металлын үйлдвэрлэл тэлнэ гэж харж байгаа аж. Мөн БНХАУ-ын Засгийн газрын НӨАТ-ыг гурван хувь бууруулах төлөвлөгөө уул уурхайн салбарынханд их биш ч гэсэн эерэг нөлөөлнө гэж үзэж байна. Түүнчлэн 2018 онд гурван хувьтай байсан дэд бүтцийн хөрөнгө оруулалтын өсөлт энэ жил 10 хувь болж өсөх төлөвтэй байгаа нь нэмэлт дэмжлэг болно гэдгийг онцоллоо.

Эх сурвалж: BloombergTv.mn

PDAC: 2018 онд эрдсийн салбарын санхүүжилт 23 хувиар буурч, 65 тэрбум ам.доллар болов

2018 онд дэлхийн хэмжээнд эрдэс баялгийн салбарын санхүүжилт буурсныг “S&P Global Market Intelligence” болон “PDAC”-ийн хийсэн судалгааны дүн харуулж байна. 2017 онд идэвхжил сэргэж, санхүүжилт 40 хувиар өсөж, 85 тэрбум ам.доллар болж байжээ.

Харин 2018 онд 65 тэрбум болж буурсан байна. Энэ нь 2012 оны оргил дүнтэй харьцуулбал хоёр дахин буурсан үзүүлэлт юм. Өнгөрсөн онд эрдсийн салбарт хийгдсэн 65 тэрбум ам.долларын санхүүжилтийн 69 хувь нь компаниуд өөрийн бизнесийн хувиас худалдаж босгосон хөрөнгө байсан бол 31 хувь нь зээл байжээ.

Зээлээс босгосон санхүүжилт өмнөх оноос 17 хувиар буурсан бол хувьцааны хөрөнгө оруулалтаар татсан санхүүжилт 34 хувиар татарсан байна. Суурь болон үнэт металлын ханшийн хэлбэлзэлтэй уялдаж санхүүжилт буурсан гэж үзэж байна. Тухайлбал, 2016 оны эхний хагас жилд үнэт металлын ханш хамгийн багадаа 20 хувь, зарим нэрийнх нь 40 хувь давж өссөн бол 2018 онд алтны ханш нэг хувиар, мөнгө өсөн хувиар, харин цагаан алт 13 хувиар тус тус буурсан байгаа юм. Зэс, никель, цайр зэрэг суурь металлуудын ханш ч мөн 2018 он эхэнд өсөж байсан бол оны төгсгөл үед бүгд буурчээ.

Эх сурвалж: BloombergTv.mn

МЭДЭГДЭЛ

Энэхүү хэвлэл /мэдээлэл, судалгаа/ нь “Ти Ди Би Капитал ҮЦК” ХХК-ийн нэрийн өмнөөс зөвхөн өөрийн үйлчлүүлэгчид /харилцагчид/-д мэдээлэл хүргэх зорилгоор бэлтгэгдсэн ба энэ нь аливаа нэг хөрөнгө оруулалтын зөвлөгөө болон аливаа санхүүгийн хэрэгслийг худалдах, худалдан авах санал биш болно. Судалгаа /хэвлэл/-г бэлтгэх үеийн байдлаар түүнд агуулагдаж буй мэдээллийн үнэн бодит байдлыг хангах талаар шаардлагатай ажиллагааг хийсэн бөгөөд “Ти Ди Би Капитал ҮЦК” ХХК нь мэдээллийн үнэн бодит байдалд баталгаа гаргахгүй. Энэхүү мэдэгдэлд агуулагдаж буй мэдээллийг үйл ажиллагаандаа шууд болон шууд бус байдлаар ашигласнаас үүдэн аливаа хувь хүн, хуулийн этгээдийн үйл ажиллагаанд учирсан хохиролд “Ти Ди Би Капитал ҮЦК” ХХК хариуцлага хүлээхгүй болно.